

Д.Тунгалаг

МУИС-ийн философиийн тэнхмийн
багш, доктор, дэд профессор

Биоэтикийн орчин үеийн асуудал

Түлхүүр уг: Ёс суртахуун, ёс суртахуунлаг, нээлттэй асуудал, мэдээлэл зөвшилцэх, идэвхитэй, идэвхигүй, сайн дурын, сайн дурын бус, эвтанази, амар үхэл, үр хөндөлт, цаазаар авах.

Эдүгээ манай орны судлаачдын бүтээлд төдий л хөндөгдж амжаагүй байгаа боловч бодит амьдралд байдаг энэхүү асуудлыг анхааралдаа хандуулахыг сонирхогч, судлаач та бүхэнд сонордуулах гэсэн санааны үүднээс эл мэдээллийн шинжтэй өгүүллэгийг толилуулж байна.

1. Биоэтикийн тухай ойлголт.

Хүний амьдралын бүх салбарт ёс суртахууны практик асуудлууд олон байдаг. Жэдийгээр ёс суртахууны онолын асуудлууд нь практик асуудалтайгаа холбоотой, харилцан уялдсан байдаг ч амьдралын олон практик асуудлуудыг бүгдийг ёс суртахууны онолын үүднээс шийдвэрлэхэд хүндрэлтэй. Тухайлбал, үр хөндөлтийг хуульчлан батлах эсэх, найдваргүй өвчтөний зовлонт амьдралыг таслан зогсоох эсэх, гэр бүл салалтыг нийгмээс хориглох эсэх, цаазаар авах явдлыг зөвтгөх эсэх гэх мэт олон асуудлууд байдаг. Эдгээр асуудлуудыг хэрхэн шийдвэрлэх талаар нийгмийн байр суурь эрдэмтдийн үзэл бодол тодорхойгүй маргаантай хэвээр байна.

Хавсарга ёс зүйн асуудалд бүрэн төгс шийдвэрлэгдэж болдоггүй асуудлуудыг “ёс суртахууны нээлттэй асуудал” гэдэг. Нээлттэй асуудлуудын нэг нь “**биоэтик**”-ийн асуудал юм.

Орчин үед өрнедийн орнуудад тухайлбал АНУ-д биоэтикийн чиглэл маш эрчимтэй хөгжиж байна. АНУ-ын нийгэм судлаачид, биологичид, эмч, мэргэжилтнүүд, шинжлэх ухааны олон салбарын хүрээнд уг асуудлыг судалж, олон тооны ном бүтээл туурвиж, биоэтикийн энциклопеди хэвлүүлснээс гадна 1988 онд Зөвлөлт-Америкийн биоэтичдийн симпозиум болсон. Гол төлөөлөгчдөөс Р.Деджордж, Б.Герт, А.Каплан, Д.Уиклер гэх мэт хүмүүсийг нэрлэж болно. Биоэтикуудийн эрлийн эхлэл нь хүн төрөлхтөний ирээдүйн тухай түгшүүр зовнил юм. Иймээс АНУ-ын эрдэмтэн биологич В.Р.Поттер “биоэтик” хэмээх ойлголтийг анх гаргаж түүнийгээ “ирээдүй рүү хүрэх гүүр” гэж нэрлэжээ.

Америкийн эрдэмтэдийн үзэж байгаагаар 60,70-аад онд хүчтэй хөгжиж эхэлсэн биоэтик нь онолын судалгаанд төдийлөн өртөөгүй, харин биологи, анагаах ухаан, хуулийн болон шинжлэх ухааны зарим салбарын практик асуудал болон тавигдаж ирсэн. Биоэтикийн ёс зүйн гол асуудал нь хүмүүнлэгийн зарчим юм. Гэвч биоэтикуудийн хүрээнд судлагдаж буй асуудлуудаар одоо хир нэгдсэн нэг санал байхгүй байна.

2. Биоэтик ба анагаах ухаан.

Биоэтикийн орчин үеийн чухал асуудлуудын нэг нь *анагаах ухааны уламжлал* болсон асуудлууд юм. Юуны өмнө “эмч-эмчлүүлэгч” хоёрын хоорондын харилцааны асуудал тэдний гол анхаарлын төвд байдаг бөгөөд үүндээ биоэтикууд эмчлүүлэгчийн оролцоог хүчтэй гаргасан байна. Ингэснээрээ “мэдээлэл зөвшүүлцөх” ёс зүйн хандлагад хүрч түүний үр дүнд гарах эрх зүйн дэмжлэгт нөлөөлөх зорилготой юм. Энэ хандлагын ёс зүйн агуулга нь хүн бүр амьдралын ямар ч үед, эрүүл мэндийн эмчилгээний ямар ч асуудлаар “асуудлыг бие даан шийдвэрлэх эрхтэй” гэж үздэг хүний эрхийн зарчмаас урган гарах хувь хүний бие даасан байдлын асуудал юм. Энэ нь “хүн өөрөө өөртөө эзэн”, ухаан санаа эрүүл саруул байгаа үедээ ямар ч нэг эмчилгээг хийлгэхгүй хориглож болно харин эмч түүний энэ шийдвэрт саад болж болохгүй гэсэн үг юм. Мэдээжийн хэрэг “мэдээлэл зөвшүүлцөх” хандлага нь маргааны гол асуудал болж шийдвэрлэгдэж чадахгүй хэвээр байгаа юм.

Биоэтикуудийн анхаарал татсан нэг хүндрэлтэй асуудал нь “эвтаназ”-ийн асуудал юм. Эвтанази гэдэг нь “amar үхэл” гэсэн утгатай үг юм. Эвтаназийн гол агуулга нь найдваргүй болсон өвчтөнг үхэлд зовлонгүй хүргэх гэсэн утга санааг агуулдаг. Орчин үеийн анагаах ухаанд найдваргүй болсон өвчтөний амьдрах хугацааг сунгах маш олон төрлийн арга, шинэ технологи бий болсон. Гэтэл тухайн өвчтөний зовлонт амьдралыг удаашруулан сунгах нь хэрэгтэй юу?, эсвэл түүнийг зовлонт амьдралаас чөлөөлөх нь зөв үү гэдэг асуудал гардаг. Энэ асуудлыг нэг мөр болгон шийдвэрлэх боломж өнөөг хүртэл гаралгүй бөгөөд ирээдүйд үг асуудлын талаар оновчтой шийдвэр гаргаж чадах эсэх тухай асуудал ч гэсэн маргаантай хэвээр байна.

Ёс суртахууны философиид эвтаназийг *идэвхтэй, идэвхгүй, сайн дурын, сайн дурын бус* гэж ангилдаг. *Идэвхигүй* эвтанази гэдэг нь эмчийн зүгээс эмчлүүлэгчийн үхлийг зөвшөөрөх, өөрөөр хэлбэл, эмч хийх ёстой эмчилгээг зогсоож, өвчтөнг хурдан үхүүлж, зовлонгоос ангижруулах үйлдэл. *Идэвхитэй* эвтанази гэдэг нь тодорхой зорилготойгоор урьдаас гаргасан шийдвэрийн дагуу

эмнэлгийн арга хэрэгслүүдийг ашиглан өвчтөнг түргэн үхүүлэх, өөрөөр хэлбэл хүчээр амьд байлгаж байгаа системийг нь салгах, тарих, түргэтгэх эм бэлдмэл өгөх зэргээр эмнэлгийн байгууллагын зүгээс хийх үйлдэл. Сайн дурын эвтанази гэдэг нь өвчтөний өөрийн хүсэлтээр үхүүлэхийг хэлнэ. Харин өвчтөн өөрөө хүслээ илэрхийлж чадахгүй ойр дотны хүмүүс нь түүний хүслийг дамжуулан гүйцэтгүүлэхийг сайн дурын бус эвтанази гэнэ. Эдгээрээс эхний хоёр нь эмчийн, сүүлийн хоёр нь өвчтөний байр суурийг илэрхийлдэг. Дээрх дөрвөн төрлийн эвтаназийг сайн дурын идэвхитэй, сайн дурын идэвхигүй, сайн дурын бус идэвхитэй, сайн дурын бус идэвхгүй гэсэн дөрвөн хэлбэрт хувааж болно. Сайн дурын идэвхитэй, сайн дурын бус идэвхигүй эвтаназийн талаар мэргэжлийн хүмүүсийн санал их зөрөлддэг. Сайн дурын бус идэвхитэй эвтаназийг олонх хүмүүс хүлээн зөвшөөрөх бололцоогүй гэж үздэг. Харин эвтаназийг дэмждэг хүмүүс сайн дурын идэвхигүй эвтаназийг хамгийн тохиромжтой гэж үздэг бөгөөд үүнийгээ дараах хоёр үндэслэлээр батлахыг оролддог.

1. Таашаал нь зовлон зүдгүүрээс, эерэг сэтгэл хөдлөл нь сөргөөсөө давамгайлсан тохиолдолд л хүний амьдралыг дээд нандин зүйл гэж үзэх хэрэгтэй.

2. Үхлийн ирмэг дээр байгаа нэг хүний амьдралыг хүчээр тэтгэн үргэлжлүүлэхэд эмнэлгийн нарийн технологи их хүч хөдөлмөр шаарддаг. Үүний оронд эмчилгээ авах боломжтой олон хүнийг эмчлэхэд дээрх хөрөнгө хөдөлмөр зориулагдах ёстой гэж үздэг.

Гэхдээ энэ нь хэт прагматик шинжтэй учир эвтаназийг хүлээн зөвшөөрөхөд ёс суртахууны оновчтой үндэслэл болж чадахгүй. Эвтаназийг амьдралд хэрэгжүүлэх нь зовлонт амьдрал, жаргалтай амьдрал хоёрын нэгний сонголт бус, амьдрал үхэл хоёрын нэгний сонголт юм. Эндээс үхэл нь зовлонт амьдралаас дээгүүр байж чадах уу? гэдэг асуулт гарна. Эвтаназийг дэмжигчид ч энэ асуултанд шууд хариулт өгч чаддаггүй. Түүнчлэн эвтаназийг ёс зүй, эрх зүйн үүднээс зөвшөөрөх нь эмч болон өвчтөний төрөл садан ойр дотныхон нь түүнийг зүй бусаар ашиглах аюулыг нэмэгдүүлэх сөрөг үр дагавартай. Гэвч биоэтикууд энэ асуудлыг шийдвэрлэж чадаагүй бөгөөд эцсийн шийдвэр гаргах асуудал нь маргаантай хэвээр байгаа. Ийнхүү эвтанази нь хэзээ нэгэн цагт шийдэгдэх эсэх нь тодорхойгүй байна.

Биоэтикт дээрхээс өөрцгүй ёс зүйн өөр олон чухал асуудал тухайлбал, үр хөндөлтийг албан ёсоор зөвшөөрөх /ул зөвшөөрөх/, гажигтай төрсөн хүүхдийг устгахыг зөвтгөх /ул зөвтгөх/ хүний эрхтнийг ашиглах боломж, хиймлээр үр

тогтоох, хүнийг анагаах ухаан ба шинжлэх ухааны туршилтанд ашиглах, психиатруудын маргаантай асуудлууд байдаг. Маргааны гол нь асуудлын аль аль талд нь ёс суртахууны болоод эрхийн асуудал яригддагт байгаа юм. Жишээ нь эрхтэн сүулгах мэс засалчид өвчтөний эрх ашгийн үүднээс өвчтөнд амьд донорын бөөр юмуу уушигны хэсгийг шилжүүлэн сүулгахад /бүр донор нь сайн дураараа зөвшөөрсөн байсан ч/ донорт хандсан ёс суртахууны тогтсон хэм хэмжээ, журам зөрчигдэж байдаг. Үр хөндөлт хийх эрх, үхэх эрх гэх мэт ойлголтууд нь хүмүүст аль хэдийн дасал болсон. Гэвч үүнийг хүний эрхийн бүх нийтийн тунхаглалд хүлээн зөвшөөрөгдөөгүй учир энэ нь хийсвэр эрх юм. Ёс суртахууны үүднээс эмэгтэй хүний эрх чөлөөтэй байх эрх, эх болох эрхийг алиныг нь хүндэтгэх ёстой ч нөгөө талд нь хүний амь, хүүхдийн эрх ашиг, эхийн эрх ашиг гэх мэт эрхийн асуудлууд хоорондоо зөрчилдэж байгаа юм.

3. Биоэтика ба хууль эрх.

Биоэтикийн бас нэг эмзэг асуудал бол цаазаар авах ялын тухай **хуулийн** асуудал юм. Хүн төрөлхтөнд цаазаар авах ял эртнээс бий болж хэрэглэсээр ирсэн. Мэдээж үүнийг онцгой тохиолдолд хэрэглэж байгаа юм. Гэвч сүүлийн үед цаазаар авах ял оноох хүмүүсийн тоо хороодж, цааз авах ялыг хэрэглэдэг улс орнуудын тоо цөөрөх хандлагатай байгаа. Олонхи оронд хүүхэд, эмэгтэйчүүд, өндөр настанд цаазаар авах ял оноодоггүй болжээ. Цаазаар авах асуудлаар өөр хоорондоо ялгаатай, заримдаа эрс тэс шинж чанартай үзэл бодол хандлагууд байдаг. Хэдийгээр ихэнх нь цаазаар авах ялыг дэмждэггүй боловч үүнийг дэмждэг хэсэг байдаг. Тэд хэд хэдэн үндэслэлээр үүнийгээ зөвтгөдөг. Үүнд: 1. Муу үйлдэлд өгч буй шударга хариу. 2. Дахин гэмт хэрэг хийхээс бусдыг урьдчилан сэргийлж, сүрдүүлэх нэгэн арга хэрэгсэл. 3. Онц аюултай гэмт хэрэгтнүүдийг нийгмээс тусгаарлаж өгдгөөрөө нийгэмд ашиг тустай хэрэгтэй зүйл. 4. Ялтны хувьд бүх насаараа хүнд хэцүү нөхцөлтэй шорон гянданд хоригдсоноос цаазаар авхуулсан нь дээр /үүнийгээ хүмүүнлэгийн үүднээс хандах оролдлого гэдэг/. 5. Цаазаар авах ял нь аюултай гэмт хэрэгтнээс ангижрах хамгийн энгийн бөгөөд хямд арга юм гэсэн үндэслэлүүдийг гаргадаг. Цаазаар авах ялыг эсэргүүцэгчид нь энэ үндэслэлийг дараах байдлаар буруушаадаг байна. Тухайлбал, цаазаар авах ял нь нийгмийн зан суртахууныг доройтуулдаг, хэрэгтнийг цаазаар авах явдал нь хууль бус үйлдэл, өөрөөр хэлбэл төрд ч хүний амийг хороох эрх байхгүй, хүний эрх мэдлийн хэмжээ цар хүрээ хязгаарыг эвдэгээрээ нийгмийн шударга ёсыг худал хуурмаг шинжтэй болгодог цаазаар авах нь хүн бол дээд үнэт зүйл гэдэг ёс суртахууны гол зарчимд халдаж, түүнийг хөсөрдүүлдэг гэж үздэг. Ингэж цаазаар авах ялыг

хүмүүсийн нэг хэсэг нь буруушааж, нөгөө хэсэг нь зөвтгөдөг боловч уг асуудлыг орчин үед нэг мөр болгон шийдвэрлэх боломж одоогоор гараагүй байна.

Ийнхүү зарим хүмүүс асуудлын нэг шийдвэрийг баттай баримталж байхад нөгөө нэг хэсэг нь өөрийнхөө шийдвэрт бүрэн итгэлтэй түүнийгээ хамгаалж байдаг. Гэвч биоэтикийн янз бүрийн асуудалд нийтлэг олон шинж байдаг. Тухайлбал, эдгээр асуудлууд нь нийгмийн хяналт болон оюуны зохицуулалтанд өртдөг нийгмийн амьдралын ил тод байдалтай шууд холбоотой байдаг. Жишээлбэл, нэгдүгээрт, цаазаар авах ял бол төрийн зүгээс гаргаж буй ухамсарлагдсан тодорхой шийдвэр байдаг учир хүн болгоны анхаарлын төвд байдаг юм. Хоёрдугаарт, биоэтикийн ээдрээтэй асуудлуудыг бүрэн шийдвэрлэхэд нарийн мэргэжлийн тодорхой мэдлэг чухал ач холбогдолтой юм. Өөрөөр хэлбэл энд ёс суртахууны зэв сонголт нь мэргэжлийн шийдвэртэй нийцэх ёстой. Жишээлбэл, хүний дотоод эрхтнүүдийг дамжуулан суулгах асуудлын талаар зохистой шийдвэр гаргахын тулд анагаах ухааны нарийн мэдлэг зайлшгүй шаардагддаг. Гуравдугаар, Эдгээр асуудлууд ёс суртахууны ерөнхий зарчмуудаас гажиж байдгийг нь тайлбарлахдаа энэ нь ёс суртахуунлаг шинжийн илрэл гэж нотлохыг оролддог. Жишээ нь, эвтаназийг хүлээн зөвшөөрөгчдийн үзснээр найдваргүй болсон өвчтөнг энэхүү зовлонт амьдралаас хагацахад туслах явдал бол нүгэл биш, харин буянт үйл мөн гэж үздэг.

Ёс зүйн үүднээс аваад үзвэл биоэтичдийг хоёр төрөлд ангилж үзэж болно. Нэгдэх нь, Ёс суртахууны сайнаас няцах тохиолдол. Үүний нэг тод жишээ бол үр хөндөлтийн тухай асуудал юм. Хэрэв үр хөндөлтийн ёс суртахууны үүднээс зөвтгөвөл хүн бол дээд үнэт зүйл гэдэг хүмүүнлэг үзлийн зарчмаас гажсан хэрэг болно. Хоёрдахь нь, мууг хийхийг ёс суртахууны үүднээс зөвттөн зөвшөөрсөн тохиолдол юм. Жишээ нь: сайны төлөө худал ярих явдал юм. Нэгэнт эмчилгээ авахаа болисон хүнд худал хэлж үнэнийг нуун дарагдуулах нь ёс суртахууны үнэнч шударга байх зарчмыг зөрчиж байгаа хэрэг юм. Ийнхүү биоэтик нь эдгээр бүх асуудлуудыг шийдвэрлэхэд нэгдсэн нэг, нэгдмэл методологийг гаргаж чадахгүй байгаа ч тэдний зарим төлөөлөгчид зарим нэг тодорхой асуудлаар шийдвэр гаргахад бага ч болов амжилт олж байгаа юм.

Холбогдох ном зохиол

1. Биоэтика: проблемы, трудности перспективы /материалы "круглого стола" / Вопросы философии. 1992. 10 /.
2. Бекаррия Ч. О преступлениях и наказаниях. М., 1995
3. Введение в биоэтику. М., Прогресс – Традиция. 1998.
4. Концепции современного естествознания. Ростов на Дону. Изд-во. "Феникс". 1997.
5. Огурцов А.П. Этика жизни или биоэтика: аксиологические альтернативы. Вопросы философии. 1994. № 3
6. Соловьев В.С. Оправдание добра. М., 1996.
7. Смертная казнь: за и против. Сост. Щишов О.Ф, Парфенова Т.С. М., 1989.
8. Рейчелс Дж. Активная и пассивная эвтаназия. Этическая мысль: Научно-публицистические чтения. М., 1990.
9. Хёсле. Философия и экология. М., изд-Фирма "Камни". 1994.
10. Философия природы: к эволюционной стратегии. М., 1995.